



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 дүгээр сарын 13 өдөр Дугаар 10

Хэрлэн сум

Х ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 10 дугаар хуралдаан 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 64,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Дорнод аймгийн нутагт гарсан ой, хээрийн түймрийн нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Аймгийн Засаг даргын тамгын газрын Цэргийн штабын дарга,
Онцгой комиссын гишүүн, хурандаа О.Ганзориг-д:

1.1.Халхгол, Матад сумдын нутаг дэвсгэрийг хамарсан ой, хээрийн түймэрт мал, зэрлэг амьтан олноор хорогдсонтой холбогдуулан Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр аймгийн Онцгой комиссын гишүүд, мэргэжлийн байгууллагуудын удирдлагуудаас мэдлэг шалгах сорил авах шалгалтыг зохион байгуулах,



Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.2.Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн мэдээгээр 9 м/с-ээс дээш салхилсан тохиолдол бүрт сумын томилгоот Шуурхай бүлгийг яаралтай цуглуулж хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах талаар сумын Онцгой комиссыг үүрэгжүүлэх тухай аймгийн Засаг даргын захирамж гаргах,

1.3.Дорнод аймгийн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарсан тохиолдолд аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга, Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч даргад шуурхай мэдэгдэх,

1.4.Сумдын хариуцлагатай эргүүл, жижүүрээс тогтоосон цагуудад мэдээлэл авч, мэргэжлийн удирдлагаар ханган хамтарч ажиллах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,

/  / М.Бадамсүрэн
/  / х/ч Б.Цогтбаяр

Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот сумдын
Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.5.Ой, хээрийн түймрийн нэн эрсдэлтэй бүс нутаг болох ОХУ-тай хил дагуу Баян-Уул, Баяндун, Дашбалбар, Чулуунхороот сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, байнгын эргүүл, жижүүрийг томилгоожуулж ажиллах,

Аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга,
Онцгой комиссын гишүүн Г.Гарамхишиг,
Байгаль хамгаалалтын захиргааны дарга Б.Эрдэнэбаяр,
Аймгийн Засаг даргын тамгын сүм хариуцсан
мэргэжилтэн Л.Цагаанхүүхэн нарт:

1.6.Аймгийн Онцгой комиссын дэргэд Гамшгаас хамгаалах шуурхай штабыг байгуулж, сумын Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Байгаль хамгаалалтын захиргааны
дарга Б.Эрдэнэбаяр,
Сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх бэлтгэл,
бэлэн байдлыг хангуулах ажлын хэсгийн дарга нарт:

1.7.Сумдад ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, байнгын хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилгоожуулах, шуурхай бүлгийн хүн хүч, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах чиглэлээр хуваарилагдсан сумдад шуурхай ажиллах,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын
дарга нарт:

1.8.Сумын Онцгой комиссын Гамшгаас хамгаалах шуурхай штаб байгуулж, хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилгоожуулж, 24 цагаар ажиллуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

